

ХУУЛЬ ЗҮЙН САЙД, ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2014 оны 12 дугаар
сарын 05 өдөр

Дугаар А/216/422

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1. “Гэмтлийн зэрэг тогтоох журам”-ыг нэг, “Цогцост шинжилгээ хийх журам”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захирал /Х.Өлзийбаяр/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Н.Амарзаяа/-т даалгасугай.
4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 189/385 дугаар тушаалаар хамтран баталсан “Гэмтлийн зэрэг тогтоох, Цогцост шинжилгээ хийх журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ТЭМҮҮЖИН

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

Н.УДВАЛ



Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын
2014 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн
216/А/05 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЦОГЦОСТ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Нас барагчийн цогцост шүүх эмнэлгийн шинжилгээ /цаашид “шинжилгээ” гэх/ хийхэд энэхүү журам болон “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам”, Монгол Улсын стандарт MNS 5733:2004, холбогдох хууль тогтоомжийг баримтлана.

1.2.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс /цаашид “шинжээч томилох этгээд ” гэх/ ирүүлсэн тогтоол, захирамжийг Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хүлээн авч, шинжээчийн мэргэжил, ажлын дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн цол зэрэг, ажлын ачаалал зэргийг харгалзан тухайн хэрэгт хувийн сонирхолгүй шинжээчид хуваарилна.

1.3.Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, криминалистикийн шинжээч фото зураг авах, видео бичлэг хийх, схем зураг үйлдэх, тэмдэглэл хөтлөх зэргээр хэргийн газрын анхны байдлыг нарийвчлан бэхжүүлсний дараа шинжээч эмч нас барагчийн цогцост /цаашид “цогцос” гэх/ үзлэг хийж, зөөвөрлөнө.

Хоёр. Цогцост шинжилгээ хийх

2.1.Цогцост дараах дарааллаар шинжилгээ хийнэ. Үүнд:

2.1.1.шинжээч томилсон тогтоол, захирамж, эмнэлгийн бичиг баримт, бусад материалтай танилцах;

2.1.2.цогцост гадна үзлэг хийх;

2.1.3.дотор эрхтэнд шинжилгээ хийж, лабораторийн шинжилгээнд дээж авах.

2.2.Цогцсыг тусгайлан тоноглогдсон зориулалтын өрөөнд зөөвөрлөн байрлуулж, шинжилгээ хийх ба харин гамшгийн байдал үүссэн буюу хөдөө орон нутагт шинжилгээ хийх, шарил шинжлэх тохиолдолд тухайн нөхцөлд тохируулан хийнэ.

2.3.Бага эмч, эсхүл мөрдөн байцаагч шинжилгээний явцад үзлэг, шинжилгээний тэмдэглэл /цаашид “тэмдэглэл” гэх/ хөтлөх ба шинжилгээ хийх үеийн цогцосны ерөнхий байдал, гэмтэл, өөрчлөлтийн фото зургийг авч, шинжилгээний бичиг баримтанд хавсаргана.

2.4.Ар гэрийн хүмүүс нь хүсэлт гаргавал цогцост шинжилгээ хийх ажиллагаанд байлцуулж болно.

Гурав. Цогцост гадна үзлэг хийх

3.1.Гадна үзлэгийг дараах байдлаар гүйцэтгэнэ. Үүнд:

3.1.1.цогцсыг зөөвөрлөх буюу хувцсыг нь тайлахын өмнө цогцосны ерөнхий байдал, сүв тус бүрээс гарсан зүйл, биед хутга, багаж болон бусад гадны биет хатгагдсан, зоогдсон эсэхийг сайтар шалгах;

3.1.2.цогцосны нас, хүйс, урт, жин, биеийн галбир, мах мариа, эрхтэний бүрэн бүтэн байдлыг тодорхойлсон гадна үзлэгийг эхлэх;

3.1.3.цогцсыг дээрээс доош, урдаас арагш чиглэлээр нэг бүрчлэн үзэж, үсний өнгө, хэлбэр, хоёр нүдний зовхи, хүүхэн хараа, хамрын хэлбэр, уруул, амны салстын өнгө, шүдний бүрэн бүтэн байдал, хоёр чихний дэлбэн, хүзүү, их бие, мөчдийн байдал, өөрчлөлт, түүнчлэн ам, хамар, чихний суваг, шээс, өтгөний тус бүрээс ялгарсан зүйлийг шалгаж, өнгө шинж байдлыг нь тодорхойлон үзлэгийн тэмдэглэлд нарийвчлан тусгах;

3.1.4.цогцосны эрт үеийн өөрчлөлт /хөрөлт, хөшилт, хүүрийн толбо, хаталт/-ийг нарийвчлан тогтоож, хожуу үеийн өөрчлөлт илэрсэн /ялзрал, саванжилт, занданшилт, намагшилт/ эсэхийг тодорхойлох.

3.2.Цогцост илэрсэн гэмтэл, өөрчлөлтийг дараах байдлаар тодорхойлж, тэмдэглэлд тусгана. Үүнд:

3.2.1.гэмтлийн төрөл;

3.2.2.гэмтлийн байрлал /үүнийг гэмтэл биеийн аль хэсэгт байгааг босоо, хэвтээ тэнхлэгийн дагуу анатомийн нэршлээр нь тодорхойлно/-ийг тодорхойлох;

3.2.3.гэмтлийн өнгө /үүнийг арьс, салстын өнгөний хувирлаар, хэрэв үндсэн өнгө биш бол ямар туяа болохыг заах, эсхүл олон улсын өнгө тодорхойлогчийг ашиглан тодорхойлно/-ийг тогтоох;

3.2.4.гэмтлийн хэмжээ /үүнийг алслагдсан цэгүүдийн хооронд перпендикуляр огтлолоор хэмжиж тодорхойлно/-г тодорхойлох;

3.2.5.гэмтлийн хэлбэр /үүнийг геометрийн дүрс, нийтлэг төстэй зүйлийн хэлбэрээр илэрхийлнэ/-ийг тодорхойлох;

3.2.6.гэмтлийн гадаргуу /үүнийг барзгар, гөлгөр, овгор, хонхор, шүүдэс бохирдолт байгаа эсэхээр тодорхойлно/-г тодорхойлох;

3.2.7.гэмтлийн зах ирмэг /үүнийг тэгш, тэгш бус, долгионтсон, шүдэлсэн, зах ирмэгт зулгаралт үүссэн, арьс хууларсан зэргээр тодорхойлно/-ийг тодорхойлох.

3.3.Цогцосны нас, хүйс, нас баралтын шалтгаантай холбоотой дараах зүйлийг тодорхойлж, тэмдэглэлд тусгана. Үүнд:

3.3.1.өвчин, эмгэгийн гадаад илрэл, хаван, тууралт, цэврүү, гүвдрүү, судас өргөссөн эсэх;

3.3.2.эмэгтэй хүний тухайд хөх, нөсөө, товчны хэлбэр, хэмжээ, гадна бэлэг эрхтэн, охин хальс, үтрээний амсар, хязан, хошногоны амсрын байдал, өтгөний сүв, үтрээ, хөхнөөс ялгарсан зүйл;

3.3.3.ураг, нярайн цогцосны тухайд, жин, урт, биеийн галбир, салиа, зунгаг,

толгойн хэмжээс, үс, шар үс, гуравдагч зовхи, чих, хамрын мөгөөрсний хэлбэржилт, хавирганы завсар, цээжний хэлбэр, хумсны ургалт, бэлгийн их, бага уруулын байдал, төмсөг хуухнагт буусан эсэх, хүйн байрлал, үрэвслийн цагираг, хүйн таслагдсан үзүүрийн байдал, /усанд дүрж үзэх/ , ихэсийн хэмжээ, жин, хэлтэнгийн тоо, цус хуралт, шохойжилт;

3.3.4.хэн болох нь тодорхойгүй цогцосны тухайд урт, жин, биеийн галбир, мах мариа, нүүрний хэлбэр, төрх, сахал, үсний байдал, мэнгэ, ургацаг, сорви, шивээс, хиймэл эрхтэн, өвчин, эмгэгийн гадаад илрэл зэрэг таньж болох онцлогуудыг.

3.3.5.мэс заслын шархны байрлал, хэмжээ, өнгөр, шархны ирмэг, мэс заслын утас, оёдлын тоо.

Дөрөв. Дотор эрхтэний шинжилгээ

4.1.Шинжээч эмч цогцосны гавал, цээж, хэвлийн хөндийн эрхтнүүдийг заавал нэг бүрчлэн шинжлэх ба шинжилгээг аль ч хөндийгөөс эхлэн хийж болно.

4.2.Цогцосны хөндийг нээмэгц дотор эрхтэний байрлал болон тухайн хөндийд шингэн, эсхүл гадны биет байгаа эсэхийг сайтар тогтооно.

4.3.Шаардлагатай үед хийн, агаарын, өөхөн бөглөөдөс илрүүлэх сорил хийнэ.

4.4.Дайвар хөндийг нээх болон мөчдийг шалгах шаардлага гарвал цогцсыг аль болох ар талаас нь нээж үзэх.

4.5.Шинжээч эмч дотор эрхтэнийг нэг бүрчлэн үзэж шинжлэн, дараах байдлаар тэмдэглэлд тусгана. Үүнд:

4.5.1.гол судасны агууламж, өргөн, уян чанар, хатуурлын товрууны илрэл, гэмтэл, өөрчлөлт;

4.5.2.бөөрний дээд булчирхайн хэмжээ, давхаргын зааг, гэмтэл, өөрчлөлт;

4.5.3.бөөрний өөхөн эд болон бөөрний хэмжээ, өнгө, гадаргуу, тогтоц, цусан хангамж, тэвшинцэр, шээлүүр, давсагны байдал, шээсний өнгө, хэмжээ, гэмтэл, өөрчлөлт;

4.5.4.улаан хоолойн агууламж, салстын өнгө, судасны өргөсөл, гэмтэл, өөрчлөлт;

4.5.5.хэл, залгиур, төвөнхийн мөгөөрс, ховч ясны гэмтэл, өөрчлөлт;

4.5.6.цагаан мөгөөрсөн ба гуурсан хоолойн агууламж, салстын өнгө, цагираг мөгөөрсний байдал, гэмтэл, өөрчлөлт;

4.5.7.цээж, хэвлийн хөндийн цуллаг эрхтнийг дээрээс доош чиглэлээр үзэж шинжлэх ба эрхтэн тус бүрийн өнгө, хэлбэр, тогтоц /хатуу, биелэг, зөөлөн, улбагар/, гадаргуу /толигор, гялгар, барзгар, овон товон, жигд бус/, ирмэг /хурц, мохоо/, хэмжээ /урт, өргөн, зузаан см-ээр/, жин /гр-аар/, цусан хангамж, бүтэц, эмгэг өөрчлөлт, гэмтлийн шинж, байрлал;

4.5.8.зүрх, үнхэлцэг гадаргуу, эдгээрийн хөндий дэх агууламж, ховдлын ханын зузаан, цусан хангамж, хавхлаасын дэлгэсэн урт, хавхлагын ба хөхлөг булчингийн байдал, титэм судасны хатуурал, сүвний нарийсал, гэмтэл, өөрчлөлт;

4.5.9.ходоод, 12 нугалаа гэдэс, цөсний хүүдий, нарийн ба бүдүүн гэдэсний

агууламж, салстын өнгө, атираа нугалаасын байдал, гэмтэл, өөрчлөлт

4.5.10.голт, уушгины уг, чацархайн тунгалгийн булчирхай, судасны салаалалт;

4.5.11.багана нуруу, нугалам, хавирга, эгэм, өвчүү, аарцаг, дээд, доод мөчдийн ясны гэмтэл, өөрчлөлт;

4.5.12.толгой хуйхны дотор тал, гавлын орой, суурь яс, тархины хатуу ба зөөлөн бүрхүүл, тархины бөмбөлөг, түүний судасжилт, тархины эдийн гэмтэл, өөрчлөлт, ховдлын агууламж, шаардлагатай тохиолдолд гавлын дайвар хөндийн агууламж.

4.6.Цогцсын эмгэг судлалын шинжилгээний дараа эрхтнүүдийг цээж, хэвлийн хөндийд буцаан хийж, биүүлэн оёж цэгцэлнэ. Цогцсыг битүүмжлэн оёсны дараа угааг арчин хуурайшуулж, цогцос хадгалах газарт шилжүүлнэ.

4.7.Цогцост шаардлагагүй зүслэг хийх, эд эрхтэнийг гэмтээх, устгах, авахыг хориглоно.

4.8.Шинжээч эмч дотор эрхтэний шинжилгээ хийх үед тогтоосон аргачлалын дагуу лабораторийн болон нэмэлт шинжилгээнд дээж авч, холбогдох лабораторид илгээлт бичгийн хамт хүргүүлэх ба уг бичигт хэний, аль эрхтэнээс хэзээ, хэдий хэмжээгээр дээж авсан, түүнд ямар төрлийн шинжилгээ хийхийг тэмдэглэж, үхлийн шалтгааныг товч бичнэ.

4.9.Цогцосноос эрдэм шинжилгээ, сургалт, эмчилгээ, оношлогооны зорилгоор шинжилгээний дээж авах тохиолдолд тэмдэглэлд тусгайлан заана.

Тав. Шинжээчийн дүгнэлт

5.1.Цогцост илэрсэн гэмтэл, өөрчлөлт, лабораторийн шинжилгээний хариу, эмнэлгийн бичиг баримт, бусад материалыг нэгтгэн үнэлж үзсэний үндсэн дээр шинжээч эмч шүүх эмнэлгийн шинжилгээний онош тавина.

5.2.Цогцосны нас барсан шалтгааныг тогтоож, онош тавихдаа шинжээч эмч “Өвчин гэмтэл ба үхлийн шалтгааны олон улсын ангилал”-ыг баримтална.

5.3.Дүгнэлтийг гаргахдаа шинжээч эмч нь эрх бүхий этгээдийн тогтоол, захирамжид тавигдсан асуултын дагуу хариулна.

5.4.Шинжээч эмч гаргасан дүгнэлтээ хуульд заасны дагуу шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтанд танилцуулснаар тухайн шинжилгээг хийж дууссанд тооцно.

5.5.Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан шинжээч эмчийн гаргасан дүгнэлтийг өөрчлөхийг хориглох ба уг албан тушаалтан нь зөвхөн өөрийн эзэмшсэн нарийн мэргэжлийн хүрээнд шинжлэх ухааны тодорхой арга зүйд тулгуурлан шинжилгээний үр дүн дүгнэлтэд үнэн зөв тусгасан эсэхтэй нарийвчлан танилцаж, мэргэжлийн зөвлөлгөө өгч болно.

5.6.Шинжээч эмч дүгнэлтийг хоёр хувь үйлдэж, эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөх ба эрх бүхий албан тушаалтан нэг хувийг шинжээч томилсон этгээдэд, үлдэх хувийг архивт хадгалана.

Зургаа. Бусад

6.1.Эмнэлгийн байгууллагад эмчлүүлж байгаад нас барсан цогцост шинжилгээ хийсэн тохиолдолд эмгэг судлал, эмнэлзүйн зөвөлгөөн хийж болох ба энэ тохиолдолд шинжээч томилсон эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авна.

6.2.Цогцост анхны шинжилгээ хийсэн шинжээч эмчийг давтан шинжилгээ хийх, шарил шинжлэх үед мөрдөн байцаагчийн зөвшөөрлөөр байлцуулж болно.

6.3.Шинжилгээ хийх ажиллагаанд дадлагажигч эмч, анагаах ухааны болон хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудыг оролцуулж болох ба шинжээч эмч тэд нарт шинжилгээний үр дүнгийн талаар урьдчилан тайлбарлахыг хориглоно.

6.4.Цогцост шинжилгээ хийсэн шинжээч эмч, шинжилгээнд оролцсон бага эмч, туслах ажилтан нар шинжээч томилсон этгээдээс бусад этгээдэд шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлэл өгөхийг хориглоно.

-----oOo-----



Хууль зүйн сайд, Эрүүл мэндийн сайдын
2014 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн
10 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГЭМТЛИЙН ЗЭРЭГ ТОГТООХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн шинжилгээ /цаашид “шинжилгээ” гэх/ хийх ажиллагаанд “Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам” болон холбогдох хууль тогтоомж, энэхүү журмыг баримтлана.

1.2. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

1.2.1. “Гэмтлийн зэрэг” гэж гадаад орчны хүчин зүйл /механик, физик, хими, биологи, сэтгэцийн/-ийн үйлчлэлийн улмаас хүний эрхтэн тогтолцооны бүтэц, үйл ажиллагаа алдагдахыг;

1.2.2. “Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд” гэж хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгч, шүүхийг;

1.2.3. “Шинжилгээний объект” гэж хүн, цогцос (цаашид “шинжлүүлэгч” гэх) болон хэргийн материал, эмнэлгийн бичиг баримтыг;

1.2.4. “Эмч-шинжээч” гэж шүүх эмнэлгийн шинжилгээнд шинжээчээр томилогдон ажиллаж буй хүний их эмчийг;

1.3. Эмнэлгийн бичиг баримт /өвчний түүх, эмчлүүлэгчийн карт, шинжилгээний хариу зэрэг/ эх хувиараа байх ба тухайн байгууллагын тамга, тэмдгээр баталгаажсан байна.

1.4. Шинжилгээг зөвхөн “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийн 37 дугаар зүйлийн 37.3-т заасан шинжилгээний байгууллагад ажиллаж буй шинжээч болон зохих журмын дагуу томилогдсон этгээд хийх ба өөр байгууллага, этгээдээр энэ төрлийн шинжилгээг дангаар нь хийлгэж, дүгнэлт гаргуулахыг хориглоно.

1.5. Шинжилгээ хийх үндэслэл нь шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн гаргасан тогтоол, захирамж (цаашид “шийдвэр” гэх) байх ба өөр байгууллага, этгээдийн гомдол, хүсэлт, шийдвэрээр энэ төрлийн шинжилгээ хийхийг хориглоно.

1.6. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд (цаашид “шинжээч” томилох этгээд гэх) энэ тухай шийдвэрээ тухайн нутаг дэвсгэрийн шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

1.7. Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан уг шийдвэрийг хүлээн авч мэргэжил, дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн цол зэрэг, ажлын ачаалал зэргийг харгалзан тухайн хэрэгт хувийн сонирхолгүй шинжээчид шинжилгээ хийлгэхээр хуваарилна.

1.8.Шинжлүүлэгч шинжилгээний байгууллагад өөрийн биеэр ирж үзлэг, шинжилгээ хийлгэх ба дараах тохиолдолд шинжээч нь хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчийн хамт шинжлүүлэгчийн байгаа газарт очиж шинжилгээ хийж болно. Үүнд:

1.8.1.Шинжлүүлэгч нь шинжилгээний байгууллагад хүрэлцэн ирэх боломжгүй хүндээр гэмтсэн, өвчилсөн;

1.8.2.Шинжлүүлэгч нь албадан саатуулах, баривчлах, цагдан хорих байр, эсхүл хорих ангид байгаа.

1.9. Шинжилгээ хийхэд дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1.9.1.Шинжлүүлэгч нь өмнө нь гэмтсэн эсхүл ямар нэг өвчтэй байсан зэргийг харгалзахгүйгээр зөвхөн тухайн үед гэмтлийн улмаас үүссэн эрүүл мэндийн хохирлын зэргийг тогтоох;

1.9.2.Шинжлүүлэгч нь нэг цагийн хугацаанд биедээ хэд хэдэн гэмтэл авсан бол шаардлагатай тохиолдолд гэмтэл тус бүрт эрүүл мэндийн хохирлын зэргийг тогтоох ба эдгээрийн аль хүндээр нь гэмтлийн зэргийг үнэлж, хэрэв эдгээр гэмтлүүд нэг нэгэндээ харилцан нөлөөлж шинжлүүлэгчийн биеийн байдлыг хүндрүүлсэн бол тэдгээрийг бүрдэл байдлаар авч үзэж эрүүл мэндийн хохирлын зэргийг тогтоох;

1.9.3.Шинжлүүлэгчийн биед илэрсэн хэд хэдэн гэмтлийг өөр өөр цаг хугацаанд үүссэн гэж үзвэл гэмтэл тус бүрт үүссэн хугацаа, үүсгэсэн хүчин зүйл болон эрүүл мэндийн хохирлын зэргийг тогтоох;

1.9.4.гэмтлийн зэргийг тогтоохдоо тухайн гэмтлийн төрөл, хэлбэр, хэмжээ, байрлал, онцлог зэргийг шинжилгээний бичиг баримтад тусгана.

1.10.Дараах тохиолдолд шинжлүүлэгчийн гэмтлийн зэргийг тогтоохдоо төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч (сэтгэц, мансуурал судлалын, эх барих эмэгтэйчүүдийн, нүүр амны-мэс заслын гэх мэт) нарыг оролцуулан бүрэлдхүүнтэй шинжилгээ хийж болно. Үүнд:

1.10.1.сэтгэцийн болон донтох өвчтэй болсон;

1.10.2.жирэмслэлт таслагдсан;

1.10.3.нүүр засрашгүй гэмтсэн.

1.11.Шинжилгээ хийх явцад нэмэлт шинжилгээ хийлгэх шаардлагатай бол төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төвөөр оношлогоо, шинжилгээ хийлгэж болох ба уг үзлэг, шинжилгээний тэмдэглэл, оношийг шинжилгээний бичиг баримтад тусгана.

1.12.Шинжлүүлэгч шинжилгээ хийлгэхээс татгалзсан, нэмэлт болон дахин шинжилгээ хийх хугацаанд хуульд зааснаас бусад шалтгаанаар ирээгүйн улмаас шинжилгээ хийх, дүгнэлт гаргах боломжгүй болсон бол энэ тухай шинжээч томилсон эрх бүхий этгээдэд мэдэгдэж, шаардлагатай тохиолдолд дүгнэлт гаргах хугацааг сунгуулах хүсэлт гаргана.

1.13.Шинжээч эмч шинжилгээ хийхдээ “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийн 13, 14 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээх ба шинжилгээний баримт бичгийг бүрдүүлж, мөн хуулийн 18 дугаар зүйлд заасан агуулга бүхий дүгнэлт гаргаж, гарын үсэг зурна.

1.14.Шинжээч эмчийн гаргасан дүгнэлттэй холбогдуулан өөр байгууллага, этгээдээр гаргуулсан дүгнэлт (мэргэжлийн, мэргэжлийн комиссын)-ийг шүүхийн шинжилгээний дүгнэлт гэж үзэхгүй.

1.15.Шинжээч эмч нь шинжилгээний явц, үр дүнг үндэслэн “Шүүхийн шинжилгээний тухай хууль”-ийн 17,18 дугаар зүйлийг тус тус баримтлан дүгнэлт гаргана.

1.16.Шүүхийн шинжилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан шинжээч эмчийн гаргасан дүгнэлтийг өөрчлөхийг хориглох ба уг албан тушаалтан нь зөвхөн өөрийн эзэмшсэн нарийн мэргэжлийн хүрээнд шинжлэх ухааны тодорхой арга зүйд тулгуурлан шинжилгээний үр дүн дүгнэлтэд үнэн зөв тусгасан эсэхтэй нарийвчлан танилцаж, мэргэжлийн зөвлөлгөө өгч болно.

1.17.Шинжээч эмч дүгнэлтээ хоёр хувь үйлдэж, бүртгэл мэдээллийн ажилтанд хүлээлгэн өгнө.

Хоёр. Гэмтлийн зэрэг тогтоох шалгуур шинжүүд

2.1.Гэмтлийн зэргийг “хүнд”, “хүндэвтэр” “хөнгөн” гэсэн ангиллаар тогтоох ба дараах үндсэн шалгуур шинжийг баримтлана. Үүнд:

- 2.1.1.амь насанд аюултай эсэх;
- 2.1.2.эрүүл мэнд сарниулсан хугацаа;
- 2.1.3.гэмтлээс үүссэн үлдэц уршиг;
- 2.1.4.ерөнхий хөдөлмөрийн чадвар алдалт.

2.2.Гэмтлийн “хүнд” зэрэгт гэмтэх үед амь нас хохирч болох амь тэнссэн байдалд хүргэсэн буюу ердийн явцаараа ихэвчлэн үхэлд хүргэх гэмтэл, гэмтлээс үүссэн үлдэц, уршиг, хөдөлмөрийн ерөнхий чадвар их хэмжээгээр алдагдсан гэмтэл хамаарах ба энэ ангиллын гэмтлийг дараах шалгуур шинжээр тогтооно. Үүнд:

- 2.2.1.амь насанд аюултай гэмтэл;
- 2.2.2.амь тэнссэн байдал;
- 2.2.3.гэмтлээс үүссэн үлдэц уршиг;
- 2.2.4.ерөнхий хөдөлмөрийн чадвар их хэмжээгээр /35-100 хувь/ тогтонги алдагдсан.

2.3.Гэмтлийн “хүндэвтэр” зэрэгт амь насанд аюултай шинж агуулаагүй гэмтэл хамаарах ба энэ ангиллын гэмтлийг дараах шалгуур шинжээр тогтооно. Үүнд:

- 2.3.1.гэмтэл, түүнээс үүссэн эд эрхтний бүтэц, үйл ажиллагааны хямрал нь эрүүл мэндийг дөрвөн долоо хоногоос дээш буюу удаан хугацаагаар сарниулсан;
- 2.3.2.ерөнхий хөдөлмөрийн чадвар үлэмж хэмжээгээр /15-30 хувь/ тогтонги алдагдсан.

2.4.Гэмтлийн “хөнгөн” зэрэгт хүнд ба хүндэвтэр зэргийн гэмтлийн шинж агуулаагүй гэмтэл хамаарах ба энэ ангиллын гэмтлийг дараах шалгуур шинжээр тогтооно. Үүнд:

- 2.4.1.гэмтэл, түүнээс үүссэн эд эрхтний бүтэц, үйл ажиллагааны хямрал нь эрүүл мэндийг дөрвөн долоо хоногоос доош буюу түр хугацаагаар сарниулсан;

2.4.2. ерөнхий хөдөлмөрийн чадвар бага хэмжээгээр /5-10хувь/ тогтонги алдагдсан.

2.5. Шинжлүүлэгчийн биед энэ журмын 2.2-2.4-т заасан шалгуур шинжүүдийн аль нэг илэрвэл энэ нь гэмтлийн зэрэг тогтоох хангалттай үндэслэл болно.

2.6. Шинжлүүлэгчийн эрүүл мэнд сарниагүй, ерөнхий хөдөлмөрийн чадвар тогтонги алдагдаагүй, ямар нэг зовиур, эмнэл зүйн шинж илрээгүй, жижиг /биеийн нийт гадаргуугийн 1 хувиас илүүгүй/ зулгаралт, цус хуралт, мөн цус хуралт, зулгаралт үүсээгүй зөөлөн эдийн няцралын үед гэмтлийн зэрэг тогтоохгүй ба шинжээч зөвхөн гэмтлийн шинж байдал, түүнийг үүсгэсэн хүчин зүйл, хугацааг тодорхойлно.

Гурав. Гэмтлийн хүнд зэргийг тогтоох шалгуур

3.1. Энэхүү журмын 2.2.1-д заасан амь насанд аюултай гэмтэлд дараах гэмтлүүд хамаарна. Үүнд:

3.1.1. гавлын хөндийрүү нэвтэрсэн шарх: Үүнд тархи гэмтсэн эсэхийг харгалзахгүйгээр толгойн аль нэг хэсгээр (хуйх, зовхи, нүд, хамар, хацар, чих, чамархай, эрүү) гавлын хөндийд нэвтэрсэн шарх хамаарна.

3.1.2. гавлын хүнхрээ ба суурь ясны хугарал Үүнд: гавлын орой (дух, зулай яс), чамархай, дагз ба суурь яс (өмнө, дунд, ар хонхор, эрвээхэй яс)-ны хугарал, заадсын салалт хамаарах ба харин ухархай ба самалдгийн дээд хана дангаараа хугарах, нүүрний яснууд ба духны хөндийн өмнөд ханын хугарал, гавлын орой ясны гадна ялтасны цууралт хамаарахгүй.

3.1.3. тархи, түүний бүрхүүл хальсны гэмтэл Үүнд: тархины хүнд зэргийн няцрал, ховдлын цус харвалт, тархины эсийн урт сэртэнгийн /аксон/ тархмал гэмтэл, түүнчлэн хатуу хальсны дээрх, доорхи цусан хураа, тархины зөөлөн бүрхүүл доорхи цус харвалт, тархины дунд зэргийн няцралын улмаас амь тэнссэн байдал илэрвэл энэ ангилалд хамаарна.

3.1.4. нугасны хөндийд нэвтэрсэн шарх Үүнд: нугас гэмтээсэн эсэхийг харгалзахгүйгээр нугасны хөндийд нэвтэрсэн шарх хамаарна.

3.1.5. хүзүүний нугалмын гэмтэл Үүнд: хүзүүний нугалмын их биеийн хугарал, мултрал, аман, хатан хүзүүний аль нэг нум, шүдлэг сэртэн, бусад нугалмын хоёр талын нумны хугарал, хүзүүний олон нугалмын хугарал, хүзүүний нугалам хоорондын жийргэвч мөгөөрс гэмтсэнээс нугас дарагдсан гэмтэл хамаарна.

3.1.6. сээр, бүсэлхийн нугалмын гэмтэл Үүнд: сээр, бүсэлхийн нугалмын их биеийн хугарал, мултрал, нумны хугарлын улмаас нугасны үйл ажиллагаа алдагдсан, нугалам хоорондын жийргэвч мөгөөрс гэмтсэнээс нугас дарагдсан гэмтэл хамаарах ба харин нугасны мэдрэлийн ёзоор цочирч рефлексийн замаар түр зуур хуниас булчин агших, сулрах, зүрх, амьсгалын хэм алдагдах хямрал энэ ангилалд хамаарахгүй.

3.1.7. нугасны гэмтэл Үүнд: нугас бүрэн ба бүрэн бус тасрах, няцрах гэмтэл хамаарна.

3.1.8. том судасны гэмтэл Үүнд: гол судас болон гүрээ, суга, бугалга, ташаа, гуя, тахим, эгэмний доорхи тараагуур, хураагуур судасны тасрал, урагдал, зүсэгдэлт түүнчлэн гэмтлийн гаралтай цүлхэн хамаарна.

3.1.9. хүзүүний гэмтэл Үүнд: залгиур, төвөнх, цагаан мөгөөрсөн болон улаан хоолойд нэвтэрсэн шарх, түүнчлэн бамбай булчирхайг гэмтээсэн шарх, төвөнх, цагаан мөгөөрсөн хоолойн цагираг мөгөөрс, хэлэн доорхи ясны хугарал хамаарна.

3.1.10. цээжний гэмтэл Үүнд: цээжний хэнхэрцгийн хэлбэр алдагдуулсан хоёр талын олон хавирганы хугарал, түүнчлэн нэг талын олон хавирга хоёр ба түүнээс дээш шугамаар хугарч хавирганы хавхлаас шинж үүсгэсэн бол энэ ангилалд хамаарна.

3.1.11. цээж, хэвлийн хөндийрүү нэвтэрсэн шарх Үүнд: дотор эрхтэнг гэмтээсэн эсэхийг харгалзахгүйгээр цээж болон хэвлийн хөндийд нэвтэрсэн шарх, түүнчлэн уг шархны улмаас үнхэлцгийн хөндий, голт, цээж, хэвлийн хөндийд цус, хий, агаар хуралдах шинж илэрсэн бол энэ ангилалд хамаарна.

3.1.12. цээж, хэвлий, аарцгийн хөндий болон хэвлийн гялтангийн гаднах эрхтний битүү гэмтэл Үүнд: цээж, хэвлий, аарцгийн хөндийн эрхтнүүд болон хэвлийн гялтангийн гаднах эрхтнүүд бяцрах, няцрах, тасрах, урагдах, задрах, үүний улмаас цээж, үнхэлцэг, хэвлийн хөндийд цус, хий, агаар хуралдсан гэмтэл хамаарах ба харин эрхтэн доргих, хальсанд цус харвах, хальс язрах гэмтэл энэ ангилалд хамаарахгүй.

3.1.13. хэвлийн гялтангийн арын зайд нэвтэрч, гялтангийн гаднах эрхтнүүдийг гэмтээсэн нуруу, ууцны доод хэсгийн шарх Үүнд: бөөр, бөөрний дээд булчирхай, шээлүүр, нойр булчирхай, дээрх болон бүдүүн гэдэсний өгсөх, уруудах хэсгийг гэмтээсэн шарх хамаарна.

3.1.14. бага аарцгийн хөндийн эрхтнүүдийн гэмтэл Үүнд: үтрээ болон шулуун гэдэсний хана, хярзангийн 3-р зэргийн урагдал, шарх хамаарна.

3.1.15. аарцаг ясны хугарал Үүнд: хоёр талын умдаг болон суудал ясны хугарал /урд хэсгийн буюу эрвээхэй хэлбэрийн хугарал/, нэг болон хоёр талын олон яс уулзах үеэр салсан хугарал /аарцгийн ар хэсгийн хугарал/, умдаг ба суудал ясны нэг болон хоёр талын хугарал нь олон яс уулзах үеэр салахтай хавсарсан хугарал /Мальгены хугарал/, нэг талын умдаг, суудал ясны хугарал нь эсрэг талын олон яс уулзах үеэр салахтай хавсарсан хугарал /Воллюмийн хугарал/ энэ ангилалд хамаарна.

3.1.16. рефлексийн бүсийн битүү гэмтэл Үүнд: төвөнх, гүрээ (каротид синус), наран сүлжээ, гадна бэлэг эрхтэн орчмын гэмтлийн улмаас амь тэнссэн байдал үүссэн нь эмнэл зүй болон бүтэц зүйн шинжээр нотлогдсон бол энэ ангилалд хамаарна.

3.1.17. өндөр ба нам хэм, хими, цахилгаан, туяаны үйлчлэлээр үүссэн гэмтэл Үүнд: биеийн нийт гадаргуугийн 15 хувиас дээш талбайг хамарсан IIIБ, IV зэргийн, 20 хувиас дээш талбайг хамарсан IIIА зэргийн, 25 хувиас дээш талбайг хамарсан II зэргийн түлэгдэлт, хөлдөлт, эдгээрээс бага талбайтай боловч түлэгдэлтийн өвчин үүсгэсэн гэмтэл хамаарна. Түүнчлэн биеийн нийт гадаргуугийн 50

хувь ба түүнээс дээш талбайг хамарсан I зэргийн түлэгдэлт, цус хуралтын улмаас амь тэнссэн байдал илэрвэл энэ ангилалд хамаарах ба түлэгдэлт, хөлдөлтийн талбайг гарын алга буюу естийн дүрмээр тодорхойлно.

3.1.18.амьсгалын замын түлэгдэлт Үүнд: дууны хөвч хавагнаж, завсар нь нарийссан түлэгдэлт хамаарна.

3.1.19.туяаны үйлчлэлээр үүссэн өвчин Үүнд: туяаны үйлчлэлээр үүссэн хүнд хэлбэрийн өвчин хамаарна.

3.1.20.чөмөгт ясны ил хугарал Үүнд: атгаал, дунд чөмөг, шилбэний шаант ясны ил хугарал хамаарна.

3.2.Эмнэлгийн тусламжийн үр дүнд энэ журмын 3.1-д заасан амь насанд аюултай гэмтлийн улмаас амь аврагдсан нь энэ шалгуур шинжийг өөрчлөх үндэслэл болохгүй.

3.3.Энэхүү журмын 2.2.2-т заасан гэмтлийн улмаас үүссэн амь тэнссэн байдалд дараах хүндрэлүүд хамаарна. Үүнд:

3.3.1.шокийн хүнд хэлбэр (III-IV зэрэг);

3.3.2.янз бүрийн шалтгаант ком (II-III зэрэг);

3.3.3.цочмог болон их хэмжээний цус алдалт;

3.3.4.зүрх судасны хурц дутагдлын хүнд хэлбэр;

3.3.5.тархины цусан хангамжийн дутагдлын хүнд хэлбэр;

3.3.6.элэг, бөөр, бөөрний дээд булчирхайн цочмог дутагдлын хүнд хэлбэр, нойр булчирхайн цочмог үхжил;

3.3.7.амьсгалын цочмог дутагдлын хүнд хэлбэр;

3.3.8.Үжлийн байдалд орох, цусан үжил, хэвлийн болон цээжний гялтангийн идээт үрэвсэл, идээт нэвчдэс;

3.3.9.мансууруулах /эмнэлгийн болон эмнэлгийн бус нөхцөлд хэрэглэдэг/, нойрсуулах, сэтгэц болон зүрх судасны системд нөлөөлөх эм бэлдмэл, архи, спиртийн төрлийн бодис, техникийн шингэн, хортой хүнд металл, хорт хий болон хоолонд хордох, амьсгал бүтэх, түүнчлэн захын цусны эргэлтийн хямралаас дотор эрхтний шигдээст эмгэг, мөчдийн үхжил болон тархи, уушигны судасны хий, өөхөн ба эдийн бөглөөдөс үүсэх, осгох, атмосферийн даралтын өвчин үүсэх, цахилгаанд цохиулах, аянганд ниргүүлэх, усгүйжих, тэжээлийн дутагдалд орох, хэт ачаалал авах зэргээс амь тэнссэн байдал /уг журмын 3.3.1-3.3.8-д заасан/ үүссэн бол энэ ангилалд хамаарна.

3.4.Энэхүү журмын 3.3-т заасан амь тэнссэн байдал нь шинжлүүлэгчийн биед учирсан гэмтэлтэй шууд шалтгаант холбоотой нь эмнэл зүйн шинж, шинжилгээгээр нотлогдсон байх ба эмнэлгийн яаралтай тусламж зайлшгүй шаардагдсан байна.

3.5.Энэхүү журмын 2.2.3-т заасан гэмтлээс үүссэн үлдэц уршигт дараахь гэмтлүүд хамаарна: Үүнд:

3.5.1.хараагүй, сонсголгүй, хэлгүй болох Үүнд: хараагүй гэдэг нь хоёр нүд бүрмөсөн харахгүй буюу нүдний хараа 0,04 ба түүнээс доош буурах, сонсголгүй гэдэг нь хоёр чих бүрмөсөн сонсохгүй буюу хамгийн ойр зайнаас/3-5см-т/ ердийн яриаг

сонсохгүй болох, хэлгүй гэдэг нь өөрийн бодол санааг бусдад үгээр илэрхийлж чадахгүй болохыг тус тус хамааруулна.

3.5.2. зарим эрхтэнгүй болох буюу тэдгээрийн үйл ажиллагаа бүрэн алдагдах Үүнд: гаргүй, хөлгүй болох буюу гар сарвуунаас, хөл тавхайнаас дээш тасрах, эсхүл тэдгээрийн үйл ажиллагаа бүрэн алдагдах, түүнчлэн хурьцах, үр тогтоох, жирэмслэх, ураг тээх, хүүхэд төрүүлэх чадваргүй болох, буюу нэг төмсөггүй болох зэрэг үлдэц уршиг энэ ангилалд хамаарна.

3.5.3. жирэмслэлт таслагдах Үүнд: гэмтлийн улмаас жирэмслэлтийн хугацаанаас үл хамааран дутуу төрөх, ураг зулбах, ураг амьгүй болох тохиолдол хамаарна.

3.5.4. нүүр засаршгүй гэмтэж, нүүрний төрх алдагдах Үүнд: нүүрэнд учирсан гэмтлийн улмаас үүссэн сорви нь тухайн хүний нүүрний төрхийг илтэд өөрчилсөн, нүүрний тэгш хэмийг алдагдуулсан, нүдний зовхи, аньсага, хамрын самсаа, уруулын хэлбэрийг алдагдуулсан буюу арьсны түвшингээс дээш овойж хатуурч, эсхүл доош татагдаж хонхойсон сорви үүссэн, нүүрний дүр төрхийг сэргээх мэс засал зайлшгүй хийгдэж засрах боломжтой гэмтлүүд хамаарна. Харин нүүрний дүр төрхийг алдагдуулаагүй сорвиуд хамаарахгүй.

3.5.5. сэтгэцийн болон донтох өвчтэй болгох.

3.6. Энэхүү журмын 2.2.4-т заасан ерөнхий хөдөлмөрийн чадвар их хэмжээгээр тогтонги байдлаар алдагдах гэмтэлд дараах хугарал, гэмтэл хамаарна. Үүнд:

3.6.1. сүүж ясны тогооны хугарал;

3.6.2. атгаал, дунд чөмөгний толгойн үен доторхи тасарсан хугарал;

3.6.3. тохойн үе үүсгэгч яснуудын ил хугарал;

3.6.4. өвдөгний үе үүсгэгч яснуудын /тойгноос бусад/ ил хугарал;

3.6.5. шагайн үеийг үүсгэхэд оролцох шаант ясны гадна ба дотор хавчаар ясны ил хугарал нь шагайн үений бүрэн мултралтай хавсарсан гэмтэл;

3.6.6. мэргэжлийн хөдөлмөрийн чадварын тогтонги алдалт.

Дөрөв. Ерөнхий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хэмжээг тогтоох

4.1. Энэ журмын 2.2.4, 2.3.2, 2.4.2-т заасан хөдөлмөрийн ерөнхий чадвар алдалтын хувь хэмжээг дор дурдсан хүснэгтэд заасны дагуу тогтооно. Үүнд:

№	Гэмтэл, гэмтлийн дараах үлдэц уршиг	Ерөнхий хөдөлмөрийн чадвар алдалт /Хувь/	
		Баруун	Зүүн
Нэг. Төв ба захын мэдрэлийн эрхтэн тогтолцоо			
1	Тархи ба гавлын хүнд гэмтлийн дараахь үлдэц уршиг:		
	1.	Байнга татаж унах /7 хоногт 1-ээс дээш удаа/	
	2.	Ой ухаан муудан танин мэдрэхгүй болж, саа илрэх	
		100	

	3.	Тодорхой зорилт бүхий ажил хийх чадваргүй болох /апракси/	
	4.	Хэлгүй болох	
	5.	Хөдөлгөөний зохицуулга бүрэн алдагдах	
	6.	Тэнцвэр эрс алдагдах	
2		Ой ухаан үлэмж муудан, үе үе татаж унах /сард 1-ээс доошгүй удаа/, тэнцвэр эрс алдагдаж, мөчдийн хөдөлгөөн, булчингийн хүч их хэмжээгээр сулрах	75
3		Ой ухаан бага зэрэг муудан, хааяа татаж унах /жилд 4-10 хүртэл удаа/, тэнцвэр их хэмжээгээр алдагдан, булчингийн хүчдэл их хэмжээгээр нэмэгдэж хүч нь их хэмжээгээр сулрах	60
4		Жилд 2-3 удаа татаж унан, тэнцвэр үлэмж хэмжээгээр алдагдаж, булчингийн хүчдэл үлэмж хэмжээгээр нэмэгдэн хүч нь үлэмж хэмжээгээр суларч, хөдөлгөөн их хэмжээгээр алдагдах	45
5		Жилд 1-ээс дээшгүй удаа татаж унан, тэнцвэр бага хэмжээгээр алдагдаж, булчингийн хүчдэл бага хэмжээгээр нэмэгдэн хүч нь бага хэмжээгээр суларч, хөдөлгөөн үлэмж хэмжээгээр алдагдах	30
6		Гавал тархины гэмтлийн дараахь зарим голомтот шинж:	
	2	нүдний аньсаганы завсрын зай өөр өөр болж алиманд нь чичирхийлэлт илэрч, хамар-уруулын нугалаас гөлийж хэл хазайх	15
7		Гавал тархины гэмтлийн дараахь вегетатив шинж:	
	Нүдний зовхи анивчин, гар хуруу чичирч, шөрмөсний рефлекс ихсэн, судасны агшилт, тэлэлтийн хямралын шинж илрэх	10	
8		Тархи доргилтын дараахь үлдэц:	
	2	нүдний аньсаганы зай өөр өөр болж, хамар-уруулын нугалаас гөлийн, нүдний зовхи ба гар хуруу чичирч, шөрмөсний рефлекс ихсэн, судасны агшилт, тэлэлтийн хямралын шинж илрэх	5
Хоёр. Хүзүү, сээр, бүсэлхий, нуруу нугасны гэмтлийн дараахь үйл ажиллагааны алдагдал			
9		2 эсхүл 4 мөч саажиж, мэдрэхүй, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа их хэмжээгээр алдагдан тэжээлийн гүн хямрал үүсч, зүрх судас, амьсгалын үйл ажиллагааны алдагдал үүсэх	100
10		1 эсхүл 2 мөч саажиж, мэдрэхүй, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа их хэмжээгээр алдагдан, тэжээлийн үлэмж хэмжээний хямрал үүсэх	60
11		1 мөч хөнгөн саажиж, мэдрэхүй, шөрмөсний рефлекс, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа үлэмж хэмжээгээр алдагдан, тэжээлийн хямрал үүсч, булчин үлэмж хэмжээгээр хатангирших	40
12		Аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа болон мөчдийн хөдөлгөөнд алдагдал илрэхгүйгээр мэдрэхүй, шөрмөсний рефлекс бага хэмжээгээр алдагдах, сулрах	15
Гурав. Хүзүү, сээр, бүсэлхийн нугалмын гэмтлийн дараахь нугасны мэдрэлийн төгсгөлийн ширхгүүдийн үйл ажиллагааны алдагдал			
13		Доод мөч бүрэн саажиж, мэдрэхүй, хөдөлгөөн, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа эрс алдагдаж, тэжээлийн гүн хямрал үүсэх	100
14		Мэдрэлийн ёзоорын мэдрэлжилтийн бүсэд мэдрэхүй эрс алдагдаж /1 ба 2 хөлний саажил/, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа үлэмж	60

		хэмжээгээр алдагдан, тэжээлийн үлэмж хэмжээний хямрал үүсэх	
15		Мэдрэхүй, ургаль мэдрэл, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа үлэмж хэмжээгээр алдагдаж, хэт өвдөлтийн шинж илрэн рефлексийн нумны алдагдал үүсч, булчин их хэмжээгээр хатангирших	40
16		Мэдрэхүй, шөрмөсний рефлекс бага хэмжээгээр алдагдан, аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа, мөчдийн хөдөлгөөнд алдагдал илрэхгүйгээр булчин бага зэрэг хатангирших	20
17		Аарцгийн эрхтнүүдийн үйл ажиллагаа, тэжээл, мөчдийн хөдөлгөөнд алдагдал илрэхгүйгээр мэдрэхүй, шөрмөсний рефлекс бага хэмжээгээр алдагдах, сулрах	5
18		Нурууны гэмтлээс үүссэн нугасны мэдрэлийн ёзоорын үрэвсэл	5
Дөрөв. Захын мэдрэлийн эрхтэн тогтолцооны гэмтлийн дараах нүүр, хэлэн доорх болон гурвалсан мэдрэлийн үйл ажиллагааны алдагдал			
